

ТӨРИЙН АЛБАНЫ УДИРДАХ АЖИЛТНЫ УЛСЫН ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОГЧДООС УЛС ТҮМЭНДЭЭ ХАНДАЖ ӨРГӨХ АНДГАЙ

Монгол Улсын төрийн албаны удирдах албан тушаалтан бид 2018 оны 9 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд Улсынхаа нийслэл Улаанбаатар хотноо хуран цуглаж, Монгол төрийн албаны үндсэн зорилгын хүрээнд тулгамдсан асуудлаа шүүн хэлэлцэж, нухацтай зөвлөлдлөө. Уудам дэлгэр Улс эх орныхоо засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, иргэн бүртээ хүрч ажиллах үүрэгтэй төрийн албан хаагч бид энэхүү зөвлөгөөнөөс өөрсдийн мэдлэг, ур чадвараа дайчлан Улсынхаа хөгжлийг урагшлуулах урам зориг, эрч хүч, цэнэг сэдэл авч, улам шургуу зүтгэхээ илтгэхийн ялдамд Улс түмнийхээ өмнө дараахь андгайг итгэл төгс өргөж байна.

НЭГ. Төрийн албан хаагчийн ёс зүйг ариунаар ашид эрхэмлэн хувь хүн, харь улс, шууд удирдлага, тодорхой байгууллага, аль нэгэн аж ахуйн газрын эрх ашгаас Улсын эрх ашгийг урьдал болгон түүнд ямагт үнэнч байж төрийн албанд ёс бусаар шургалж ичгүүрт хоч, хаяг шошиг зүүхгүйн төлөө чармайн ажиллана.

ХОЁР. Монгол Улсын төрийн жинхэнэ албанд иргэд чөлөөт, өрсөлдөөнт шалгалтын замаар мэдлэг, ур чадвараа шудрагаар үнэлүүлж орох замд саад тотгор учруулах шившигт үйл ажиллагаанд бие, сэтгэл, үг хэлээрээ оролцохгүй.

ГУРАВ. Ах дүү, хамаатан садан, танил, талаа дотночлон бусдаас илүү үзэж хэрэг явдлыг нь ёс бусаар бүтээж өгдөг уршигт үзэгдлийг төрийн албанаас шахах талаар санаачилгатай ажиллана.

ДӨРӨВ. Улс төрийн талаар төвийг сахиж, төрийн хүний төрхтэй байх хуулиар тодорхойлогдсон зарчмаа сахин, аль нэгэн нам, улс төрчийн ивээл хамгаалалд орохыг эрмэлзэн, аялдан зулгуйдагч, дагалдан баясагч байхаас эрс зайлсхийж, төрийн албандаа ямагт төвч байр суурийг сахина.

ТАВ. Албаны шугамаар олж авсан мэдээ, мэдээлэл, баримт сэлтийг өөрт ашигтайгаар эсвэл бусдад хортойгоор ашиглах, өөрсдийн ажиллаж байгаа болон бусад төрийн байгууллагатай холбоотой аливаа аж ахуйн үйл ажиллагаанд хувийн ашиг хонжоо, сонирхолд хөтлөгдөн шууд ба шууд бусаар хутгалдан орохгүй.

ЗУРГАА. Гар харах, тал тохой татах, өнгө, царайд унах элдэв муу зуршлаас эрс татгалзаж, ажиллаж байгаа албаныхаа хүрээнд авилга, хээл хахуулийн аливаа илрэлийг эрс эсэргүүцнэ.

ДОЛОО. Төрийн үйлчилгээг түмэн олонд хүргэхдээ хэнийг ч үл ялгаварлан наран мэт тэгш, түгээмлээр хандаж, хүнлэг энэрэнгүй, соёлч боловсон, чанарлаг, сэтгэл хангалуун байлгахыг эрхэмлэнэ.

НАЙМ. Дэвшүүлсэн зорилтыг гүйцэлдүүлэхдээ хамгийн бага зардлаар хамгийн их үр дүнтэй, бүтээмжтэй ажиллахыг эрмэлзэнэ.

ЕС. Улсынхаа хуулийг дээдэлж төрийн албаны ёс зүйг хүндэтгэж, хуулиар тогтоосон мэдлэг ур чадварын шалгуур, шаардлагыг бүрнээ ухамсарлан ойлгож,

ТӨРИЙН АЛБАНЫ УДИРДАХ АЖИЛТНЫ УЛСЫН ЗӨВЛӨГӨӨН-2018 ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн суурь зарчим болох чадахуйн (мерит) зарчимд суурилсан төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

НЭГ. ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ТАЛААР

- Чадахуйн болон шатлан дэвших зарчмыг Төрийн албаны тухай хуулийг дагалдаж гарах бүх журам, хүний нөөцийн удирдлагын заавар, зааварчилгаад тусгаж, чанд мөрдөж ажиллах;
- Төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах, хариуцлага тооцохтой холбоотой журмуудыг тухайн ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа хүмүүст энгийн ойлгомжтой, хэрэглэхэд хялбар, дэлгэрэнгүй аргачилсан заавар, зааварчилгаа хэлбэрээр боловсруулах, журмыг боловсруулж батлахад төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах, төрийн албан хаагчдын зүгээс гарч буй саналыг тусгах;
- Төрийн албаны тухай хуулийн үзэл баримтлал, заалтуудыг нэг мөр ойлгож, эрх бүхий этгээд өөрийн сонголтын дагуу тайлбарлах, хэрэглэхээс зайлсхийх зорилгоор төрийн албан хаагчдад зориулсан дэлгэрэнгүй тайлбар, зааварчилгааг гаргаж, сургалт зохион байгуулах;
- Төрийн албан хаагчийн шалгалтын агуулгыг хуулийн хатуу мэдлэгээс илүү хувь хүний зан үйл, хандлага, тухайн ажил үүргийг гүйцэтгэх ур чадварыг тодорхойлох хэлбэрээр өөрчлөн шинэчлэх, хандлага гэдгийг шинжлэх ухаанчаар тодорхойлж, нэгдсэн журмаар хэрэглэх;
- Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалд тавигдах тусгай шаардлага, хүлээх хариуцлага, сургалтын хэрэгцээг төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл бүрээр нарийвчлан тогтоож, журамд тусгах;
- Ажлын байрны үнэлгээ хийх, албан тушаалын тодорхойлолт боловсруулах талаар төрийн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнуудад сургалт зохион байгуулах;
- Ажлын байрны дүн шинжилгээ, байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийж, орон нутаг дахь ажлын ачааллыг жигдрүүлэх;

- Төрийн албаны хүний нөөцийн хөгжлийн нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, төрийн албан хаагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахад үндэслэл болохуйц төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлж, бодит хэрэглээ болгох;
- Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт, томилгоотой холбоотой маргааныг шийдвэрлэхэд Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн эрх хэмжээг тодорхой болгох;
- Төрийн албаны тухай хууль ба бусад хуулийн уялдааг хангах зорилгоор эрх зүйн дүгнэлт хийх ажлыг зохион байгуулах;
- Орон нутаг дахь төрийн жинхэнэ албан хаагчийн томилгооны асуудлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд зохистой шийдвэрлэх;
- Төрийн албаны тухай шинэ хуулийн дагуу төрийн албаны хүний нөөцийн удирдлагын олон чиг үүрэг Төрийн албаны зөвлөлөөс Засгийн газарт шилжиж буйтай холбогдуулан эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэх бүтэц, орон тоог Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт бий болгох;
- Төрийн албаны тухай шинэ хуулийн дагуу шатлан дэвших тогтолцоонд шилжих шилжилтийн бодлого, төлөвлөгөөг боловсруулж, төрийн албан хаагчдад танилцуулах.

ХОЁР. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ, ЧАДАВХЖУУЛАХ ТАЛААР

- Төрийн албан хаагчийг сургаж хөгжүүлэхдээ төрийн албан тушаалын ангилалд нийцүүлэн мэргэшүүлж бэлтгэх, харин тодорхой албан тушаалд томилогдсон албан хаагчийг тухайн байгууллага, албан тушаалын чиг үүрэг, онцлогт нийцүүлэн богино хугацааны зорилготой сургалтад хамруулан бэлтгэх;
- Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийг албан тушаалын ангилал, зэрэглэл тус бүрээр ялгаатай боловсруулж, батлах;
- Төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлж бэлтгэх шинэ тогтолцоонд бүрэн шилжих хүртэл төрийн захиргааны байгууллагад одоо ажиллаж байгаа албан хаагчдыг тодорхой шалгуураар сонгон шалгаруулж, холбогдох ангиллын мэргэшүүлэх багц сургалтад ээлж дараатай хамруулах;
- Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтыг албан тушаал дэвшүүлэх, цалинг нэмэгдүүлэх зэрэг урамшууллын тогтолцоотой нягт уялдуулах;
- Төрийн албан хаагчдын сургалт, төрийн удирдлагын судалгаа, төрийн байгууллагад өгөх зөвлөх үйлчилгээний нэгдлийг хангах;

- Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллагын багшлах хүний нөөц, сургалтын баазыг бэхжүүлэх.

ГУРАВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН САХИЛГА, ХАРИУЦЛАГЫН ТАЛААР

- Төрийн албан хаагчийн ёс зүй болон сахилгын хэм хэмжээ, зөрчлийн төрлийг зааглан тодорхойлж, хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд бодитой хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэслэл, журмыг боловсруулж хэрэгжүүлэх;
- Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын зөрчилтэй холбоотой шийдвэрийг нийтэд ил тод зарлаж байх;
- Төрийн албан хаагчдын ёс зүйн асуудлыг хариуцсан төвлөрсөн бүтэц буюу хороог Төрийн албаны зөвлөлийн дэргэд байгуулах
- Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын зөрчилд хариуцлага тооцоход хууль хоорондын уялдаа, үйлчлэх эрх зүйн хүрээг тодорхой болгох (Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Авлигатай тэмцэх, Сонирхлын зөрчлийг зохицуулах тухай, салбарын хууль гэх мэт)
- Иргэдийн төрд итгэх итгэлийг сэргээх цорын ганц арга зам нь төрийн албан хаагчдын шударга, ёс зүйтэй, хариуцлагатай байдал гэдгийг ухамсарлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгох.

ДӨРӨВ. ИРГЭН ТӨВТЭЙ, ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН ТӨРИЙН АЛБАНЫ ТАЛААР

- Төрийн байгууллага, төрийн албан хаагчдын үйл ажиллагаа иргэдийн амьдралыг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй, үр ашигтай, чанартай хүргэхэд чиглэгдэх буюу иргэн төвтэй байх үзэл баримтлалыг байгууллага, албаны тушаалтны ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийн үнэлгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээний бүхий л үе шатанд нэвтрүүлэх;
- Байгууллагын стратегийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах журмыг энгийн, ойлгомжтой, үр дүнд чиглэсэн байдлаар, гүйцэтгэлийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийн хамт боловсруулж, хэрэгжүүлэх;
- Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөө боловсруулах, үнэлэх журмыг практикт урган гардаг асуудлууд буюу мөнгөн урамшуулал, тухайн ажилтны мэдлэг, үр чадварыг хөгжүүлэх, хариуцлага тооцохтой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглүүлэн сайжруулан боловсруулах;
- Төрийн байгууллага, албан тушаалтны ажлын үр дүнг хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны тусламжтайгаар үнэлгээ өгөх аргачлалыг боловсронгуй болгох.

ТАВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАТАЛГААНЫ ТАЛААР

- Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, нийгмийн баталгааг дордуулахгүй, өнөөгийн хүрсэн түвшнээс бууруулахгүй байх зарчим баримтлах;
- Төрийн албан хаагчийн үндсэн цалинг тогтоохдоо тухайн төрийн албан тушаалыг эрхлэхэд шаардагдах мэргэжлийн үр чадвар, хүлээх хариуцлага, ажлын ачаалал, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл зэргийг харгалзаж, адил үнэлэмж бүхий ажилд адил хэмжээний хөлс олгох зарчмыг баримталж, бодитой, шударга тогтоох;
- Төрийн албан хаагчид зэрэг дэв олгох, нэмэгдүүлэх, бууруулах, хүчингүй болгох, холбогдох нэмэгдлийг олгохдоо төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх шинэ арга зүйтэй уялдуулж, ил тод, шударга байдлыг хангах;
- Төрийн албан хаагчийн ажлын үр дүн, гүйцэтгэлийг бодитой үнэлж тогтоох арга зүйг боловсронгуй болгох, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажил, үүргийн хүрээнд гүйцэтгэлийг үнэлэх замаар улирлын үр дүнгийн урамшуулал, нэмэгдэл олгох, шатлан дэвших нөхцөлийг бүрдүүлэх, төрийн байгууллагын түвшинд үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх зорилгод нийцүүлэх;
- Төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн хэмжээг ажилласан хугацаатай уялдуулж, төрийн жинхэнэ албаны мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хангах зорилгоор төрийн албан хаагчийг тэтгэвэр тогтоолгохоос өмнө тасралтгүй 5-аас доошгүй жил ажилласан байх нөхцөл, шалгуурыг журамлах;
- Төрийн албан хаагчийн цалинг инфляцийн түвшин, эдийн засгийн өсөлттэй уялдуулан жил бүр нэмэгдүүлэх.
- Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөнөөс гаргасан энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад уриалж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ УДИРДАХ АЖИЛТНЫ УЛСЫН ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОГЧИД